



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2023 оны 05 сарын 11 өдөр

Дугаар 184

Улаанбаатар хот

Хөрөнгө данснаас хасах зөвшөөрөл олгох  
тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 2.1, 2.5, 6.4, 6.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Авлигатай тэмцэх газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 81,379,000.00 (наян нэгэн сая гурван зуун далан есөн мянган) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан биет бус хөрөнгийг данснаас хасч газар эзэмших эрхийг нийтийн эзэмшилд шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар  
3. Баасаннямд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2023 оны 05 дүгээр сарын 18-ны/ний өдрийн  
..... дугаар тогтоолын хавсралт

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,  
ДАНСНААС ХАСАХ БИЕТ БУС ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Биет бус хөрөнгийн нэр, хаяг	Ашиглаж эхэлсэн он	Дуусах хугацаа он	Тоо хэмжээ	Хэмжээ (м2)	Нийт үнэ (төгрөг)
1	УБ, ХУД-ийн 15-р хорооны нутаг дэвсгэрт байрлах 850 м.кв орон сууцны зориулалттай газар	2021	2036	1	850	81,379,000
НИЙТ ДҮН						81,379,000 (наян нэгэн сая гурван зуун далан есөн мянган төгрөг)